

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн товч танилцуулга	8
1.2. Үйлдвэрийн хүчин чадал.....	9
1.3. Үйлдвэрийн тоног төхөөрөмж.....	9
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	12
2.1. Монгол орны уур амьсгал	12
2.2. Дорнод аймгийн уур амьсгалын горим.....	12
2.3. Хэрлэн сумын уур амьсгалын горим	14
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	17
3.1.Нөлөөллийн хэлбэр үргэлжлэх хугацаа.....	17
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	20
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	21
6. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	24
7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө Төслийн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвийг хамгаалах зорилгоор төсөл хэрэгжүүлэгч нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:.....	25
8. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	26
9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	28
10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	29
11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	31
12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	32

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн талбайн солбицол.....	3
Хүснэгт 2. Бүтээгдэхүүний төрөл	9
Хүснэгт 3. Бетон зуурмагийн узелийн тоног төхөөрөмжийн үнийн жагсаалт	9
Хүснэгт 4. Төмөр замын бетон дэр үйлдвэрлэх тоног төхөөрөмжийн жагсаалт	10
Хүснэгт 5. Бетон тулгуур үйлдвэрлэх тоног төхөөрөмжийн жагсаалт	10
Хүснэгт 6. Чойбалсан сумын уур амьсгалын олон жилийн дундаж үзүүлэлт	14
Хүснэгт 7. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр	17
Хүснэгт 8. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нэгтгэл.....	20
Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	21
Хүснэгт 10. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	24
Хүснэгт 11. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	25
Хүснэгт 12. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	28
Хүснэгт 13. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	26
Хүснэгт 14. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	31
Хүснэгт 15. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хуваарь.....	29
Хүснэгт 16. БОМТ-ийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	32

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Засаг захиргааны зураг	5
Зураг 2. Төслийн талбайн байршлын зураг.....	6
Зураг 3. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг	7
Зураг 4. Үйлдвэрийн гадна тал.....	8
Зураг 5. Үйлдвэрийн ажилчдын оффис	8
Зураг 6. Үйлдвэрийн бүтээгдэхүүний талбай	9
Зураг 7. Үйлдвэрийн тоног төхөөрөмж	11
Зураг 10. Агаарын жилийн дундаж температур, жилийн нийлбэр хур тунадас	13
Зураг 11. Агаарын температур болон хур тунадасны олон жилийн хандлага	13
Зураг 12. Чойбалсан сумын агаарын температур	15
Зураг 13. Чойбалсан сумын салхины хурд.....	15
Зураг 14. Чойбалсан сумын салхины зүг, чиглэлийн давтагдал.....	16
Зураг 1. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн мониторингийн цэгийн зураг.....	30

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт орших “Төмөр бетон хийц эдлэл, төмөр бетон дэрний үйлдвэр, агуулах”-ын төслийн Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайланг “Дорнод ган хийц” ХХК-тай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу Байгаль орчны үнэлгээ, судалгааны “Баялаг Баян Ундарга” ХХК боловсруулав.

Төслийн нэр : “Төмөр бетон хийц эдлэл, төмөр бетон дэрний үйлдвэр, агуулах”-ын төсөл.

Төслийн зорилго: Энэхүү төслийн зорилго нь монгол улсын дэд бүтцийн салбарт эрчимтэй хөгжиж буй төмөр зам, эрчим хүч, холбооны салбарын төмөр бетон дэр болон хүчитгэсэн тулгуурын өсөн нэмэгдэж буй хэрэгцээний тодорхой хувийг хангах, мөн байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй, хаягдалгүй технологийн аргаар боловсруулсан, олон улсын стандартын шаардлагыг бүрэн хангасан, орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан төмөр бетон эдлэлийн болон нэгдсэн удирдлагат Цогц үйлдвэр барихад оршино.

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:

- “Дорнод ган хийц” ХХК
 - Хувийн хэргийн дугаар: 0711010128
 - Регистрийн дугаар: 6095186

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг, утас:

- Дорнод Хэрлэн , 1-р баг, Үйлдвэрийн барилга
- Утас: 976-99114923

Төслийн байршил:

Дорнод аймгийн Чойбалсан хотын Хэрлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлана.


- Талбайн хэмжээ: 28390 м²
- Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: М-50-134

Газарзүйн солбицол:



Хүснэгт 1. Төслийн талбайн солбицол

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	114	34	4.1	48	4	40.3
2	114	34	3.8	48	4	42.7
3	114	34	3.4	48	4	45.5
4	114	34	4.3	48	4	45.5
5	114	34	5	48	4	45.6
6	114	34	5.3	48	4	45.6
7	114	34	5.5	48	4	45.6
8	114	34	5.5	48	4	45.6
9	114	34	5.5	48	4	45.6
10	114	34	6.1	48	4	45.6
11	114	34	6.4	48	4	45.7
12	114	34	7	48	4	45.7
13	114	34	7	48	4	45.7

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
14	114	34	11.7	48	4	46
15	114	34	11.7	48	4	46
16	114	34	11.9	48	4	46
17	114	34	16.1	48	4	46.2
18	114	34	16.2	48	4	46.1
19	114	34	16.3	48	4	45.3
20	114	34	16	48	4	45.3
21	114	34	16.3	48	4	43.3
22	114	34	16.2	48	4	43.3
23	114	34	15.8	48	4	43.3
24	114	34	13	48	4	43.1
25	114	34	12.9	48	4	43.1
26	114	34	12.8	48	4	43.2
27	114	34	12.3	48	4	43.1
28	114	34	12.6	48	4	41.7
29	114	34	12.7	48	4	40.8



Зураг 1. Засаг захиргааны зураг



ТАНИХ ТЭМДЭГ


★ Төсөл хэрэгжих газар

Масштаб 1: 100 000

0 140 280 560 Kilometers

Координатын систем: WGS 1984 UTM Zone 50N

Зураг 2. Төслийн талбайн байршилн зураг



Зураг 3. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг

1.1. Төслийн товч танилцуулга

Үйлдвэрийн барилга нь 16x18 хэмжээтэй хүчитгэсэн бетон тулгуурын барилга ба 117x31 хэмжээтэй төмөр замын төмөр бетон дэргийн барилга, Зуурмагийн узель, Агуулах, түүхий эд хадгалах байр, ажлын байр-оффис гэсэн үндсэн хэсгээс бүрдэнэ. Хүчитгэсэн төмөр бетон дэр болон ЦДАШ-ын бетон тулгуур шонгийн үндсэн түүхий эд нь өндөр маркийн портланд цемент болон суналтын өндөр бат бэхтэй ган утас болно. Дотоодоос “Хөтөл цемент шохой” ХК, Монполимет групп-н “Сэнж сант” ХХК нарын үйлдвэрлэдэг цементийг ашиглах боломжтой ба жижиг төмөр эдлэлүүдийг “Ган хийц” ХК дээр бэлтгэж, ган утсыг БНХАУ-аас импортлохоор тооцож байна. Тус компани нь 2004 оноос хойш ЦДАШ-ын хүчитгэсэн бетон тулгуур шон үйлдвэрлэж, 2015 оноос Төмөр замын төмөр бетон дэргийн үйлдвэрээ Зүүн бүсийн тулгуур төв Дорнод аймагт байгуулан ашиглалтад оруулсан бөгөөд энэ чиглэлийн мэргэшсэн боловсон хүчинтэй.



Зураг 4. Үйлдвэрийн гадна тал



Зураг 5. Үйлдвэрийн ажилчдын оффис

1.2. Үйлдвэрийн хүчин чадал

Энэхүү төслөөр хүчитгэсэн бетон тулгуурын үйлдвэр нь өдөрт 12 ширхэг, сард 260 ширхэг, жилд 3000 ширхэг төмөр бетон тулгуур үйлдвэрлэх ба Төмөр бетон дэрийн үйлдвэр нь сард 25000-30000 ширхэг жилд 300000-350000 ширхэг бетон дэр үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр болох юм.



Зураг 6. Үйлдвэрийн бүтээгдэхүүний талбай

Үйлдвэрийн техник тоног төхөөрөмжийг сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий иж бүрэн тоног төхөөрөмж худалдаж авах бөгөөд Уг төсөл хэрэгжсэнээр эхний 2 жил УКШ - 12.35.19 төрлийн төмөр бетон тулгуур, 1520 мм-ын өргөн царигийн бетон дэр, даацын болон даацын бус угсармал бетон хийц эдлэл үйлдвэрлэх ба цаашид хүчин чадал, төрөл загварын сонголтыг нэмж хэд хэдэн төрлийн төмөр бетон эдлэлийг үйлдвэрлэнэ. Үүнд:

Хүснэгт 2. Бүтээгдэхүүний төрөл

№	Хүчитгэсэн бетон тулгуурын төрөл	Төмөр замын бетон дэрийн төрөл
1	Бетон тулгуур УКШ 8.26.15	Пандрол бэхэлгээт 1520 мм царигын дэр
2	Бетон тулгуур УКШ 9.27.15	Пандрол бэхэлгээт 1435 мм царигын дэр
3	Бетон тулгуур УКШ 10.32.19	Арс бэхэлгээт 1520 мм царигын дэр
4	Бетон тулгуур УКШ 11.34.19	Арс бэхэлгээт 1435 мм царигын дэр
5	Бетон тулгуур УКШ 15.39.19	CZ бэхэлгээт 1520 мм царигын дэр
6	Бетон тулгуур ЗТБ 35.04.18а	CZ бэхэлгээт 1435 мм царигын дэр
7	Бетон тулгуур ЗТБ 110.04.22а	

Тус үйлдвэр нь дараах бүтцээр ажиллана.

1. Үйлдвэрийн төмөр бетон дэрний цех – жилд 350 000 ширхэг
2. 150, 250, 410, 600 марктай бетон зуурмагийн цех – жилд 80 000 м³
3. Элс хайрга дайрга бутлан ангилах – жилд 60 000 м³
4. Эрчим хүчний тулгуурын цех 7-22,6 м урттай өндөр хүчдэлийн агаарын шугамын тулгуур
5. Иж бүрэн лаборатори гэсэн бүтэцтэй байна.

1.3. Үйлдвэрийн тоног төхөөрөмж

Хүснэгт 3. Бетон зуурмагийн узелийн тоног төхөөрөмжийн үнийн жагсаалт

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг
1	Ерөнхий төхөөрөмж	1
2	Ган угсралтын төмөр	1

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг
3	6+15л жинлүүр	1
4	6+15+30л жинлүүр	1
5	Элс хадгалах сав	1
6	Цемент силос	1
7	Цементийн силосын нэмэгдэл тоног төхөөрөмж	1
8	Шнекен тээвэрлэгч	1
9	Удирдах систем	1
10	Цахилгаан түгээх систем	1
11	Удирдлагын хяналт	1
12	Кабель	1
13	Халуун усны төхөөрөмж	1
14	Дулаан хэмжигч	1
15	Силос дүүргэгч	1
16	Гэрэлтүүлэг	1
17	Камерын систем	1
18	Контейнер	1
19	Агааржуулалтын систем	1
20	Бусад тоноглол	1
21	Зуух	1

Хүснэгт 4. Төмөр замын бетон дэр үйлдвэрлэх тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Тоног төхөөрөмжийн нэр	Үзүүлэлт	Тоо
1	Зуурмаг өгөгч	3000 мм	3
2	Резинен урсаг зам	1000 мм *15 м	1
3	Хэв дарагч	10	3
4	Төмөр утас тастагч машин	10 мм	3
5	Тусгаарлагч төмөр утас тастагч	10	3
6	Хэв салгагч	10	3
7	Кран	5 т-5,5 м	6
8	зуурагч	1500	1
9	Цемент хадгалах сав	60	2
10	Элс угаагч машин цогц	20	1
11	Татах сунгах машин	5 т	3
12	Резинен урсаг зас	1000 мм*18 м	1
13	Тохируулагч машин	1600	1
14	Даралтгүй уурын зуух	0,35 т	3
15	Дулаан хадгалдаг сав	100 мм	

Хүснэгт 5. Бетон тулгуур үйлдвэрлэх тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо	Марк
1	Ковш	1	ZI-20
2	Арматур таслагч	1	J3GG-400
3	Тавлагч	1	ZB2*250
4	Сунгагч	1	ZB2*2/50
5	Бетон зуурагч	1	JS-500
6	Хэв	6	DMZ 190*12

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо	Марк
7	Хэвний эргэх төхөөрөмж	1	JZ1/c
8	Шарах камер	1	
9	Уурын зуух	1	LSG-0.5-0.7
10	Цахилгаан тенг	2	CD5T6M
11	Бункер	1	ЗЛБ-1200
12		1	



Зураг 7. Үйлдвэрийн тоног төхөөрөмж

1.4.Төсөл хэрэгжих орчны дэд бүтэц

- *Усан хангамж:* Унд, ахуй болон технологийн хэрэглээний усыг Дорнод аймгийн УСУГ-тай хийсэн гэрээний дагуу төвийн шугамаас хангадаг;
- *Цахилгаан эрчим хүч, дулааны хангамж:* Төвлөрсөн цахилгааны эх үүсвэрээс хангадаг;
- *Харилцаа холбоо:* Үүрэн холбооны операторууд болох Mobicom, Skytel, Unitel, G-mobile операторуудын сүлжээгээр холбоо барих бүрэн боломжтой;

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Монгол орны уур амьсгал

Монгол орон гадаад далай тэнгисээс ихээхэн алслагдсан, Евро-Азийн эх газрын төвд тал бүрээсээ өндөр уул нуруугаар хүрээлэгдсэн, далайн түвшнээс өндөр өргөгдсөн зэргээс шалтгаалан эх газрын эрс тэс, хатуу ширүүн уур амьсгалтай. Уур амьсгалын гол онцлог нь жилийн дөрвөн улирлын ялгаа ихтэй, энэ чанараараа агаарын температурын хэлбэлзэл өндөр, хур тунадас бага, уур амьсгалд өргөргийн болон өндрийн бүслүүрийн ялгаа тодорхой илэрдэг явдал юм (УАӨҮИ, 2014). Уур амьсгалыг ихэнхдээ температур, хур тунадас, салхи зэрэг газрын гадарга орчмын цаг уурын хэмжигдэхүүнийг ашиглан илэрхийлдэг.


Монгол орны жилийн дундаж агаарын температур өндөр уулын бүс тэдгээрийн хоорондын хөндий, хоолой, томоохон голын хөндийгөөр $-6...-8^{\circ}\text{C}$ хүйтэн байдаг бол өмнийн говь, цөл нутагт $+6^{\circ}\text{C}$ -аас дулаан байна. Өөрөөр хэлбэл, жилийн дундаж агаарын температур нь манай орны баруун болон хойд хэсгийн уулархаг нутагт хасах, харин түүнээс урагших тал хээр говь цөлийн нутгаар нэмэх утгатай байдаг байна. Монгол орон ерөнхийдөө хуурай, хуурайвтар уур амьсгалын бүсэд орших тул хур тунадас бага ордог. Өндөр уулсын таг, тундрийн бүсэд 400 мм-ээс дээш Хангайн нуруу, Хөвсгөл, Хэнтийн уулсаар 300...400 мм, Монгол Алтайн болон ойт хээрийн бүсэд 250...300 мм, хээрийн бүсэд 150...250 мм, говь цөлийн бүсэд 50...150 мм орчим хур тунадас унана. Мөн өргөн уудам нутагтай, газрын тогтоц, хотгор гүдгэрийн байдал, газарзүйн онцлог нөхцөл байдлаас шалтгаалан хур тунадас хойноос урагш, зүүнээс баруун тал руу буурдаг бөгөөд ордог хур тунадасны 80-аас дээш хувь нь дулааны улиралд түүний дийлэнх нь 7 болон 8 сард ордог ороо онцлогтой (Дагвадорж. Д, 2015).

Сүүлийн 80 гаруй жилийн хугацаанд манай орны жилийн дундаж агаарын температур 2.25°C -ээр нэмэгдсэн нь дэлхийн дундаж өөрчлөлттэй харьцуулахад өндөр үзүүлэлт юм. Түүнчлэн сүүлийн 45 жилд хүйтэн өдрийн тоо дунджаар 15 хоногоор буурч, халуун өдрийн тоо 24 хоногоор нэмэгджээ. Дулааны улиралд орох хур тунадас буурч хуурайших хандлагатай байна (БОАЖЯ, 2020).

2.2. Дорнод аймгийн уур амьсгалын горим

Дорнод аймаг нь далайн түвшнээс дээш 580-1000 метр өргөгдсөн, ухаа гүвээ, тэгш талархаг гадаргатай. Аймгийн баруун хойд талаараа Хэнтийн нурууны салбар Эрээн давааны нуруу, Цагаан даваа, Бумбатын даваа, Энх, Жаварт хошуу, Дэл, Онцгой, Хараат, Бүрэнхаан уул, Эрдэнэ-уул, хойд болон зүүн хойд талаараа Хурам хан уул, Шивээт уул, Хөх уул, Модот уул, Хөгнө, Мардай, баруун талаараа Өгөөмөр уул, Баян хан уул, Өвөр уртын уул, баруун өмнө талаараа Матад уул, Гүн өндөр уул, Тосон уул, зүүн, зүүн өмнөд хэсгээрээ Их Хянганы салбар Нөмрөг, Соёлз зэрэг уул, даваа, гүвээ дов толгод оршино. Дорнод аймагт Чойбалсан, Улз, Халх, Нөмрөг, Алтан,Түргэн, Дөч, Тамсаг булаг гэх мэт гол горхи,булаг шандтай. Буйр, Сангийн далай, Хөх, Яхь, Эрээн, Галуут, Хөөвөр, Хотонт, Дэлгэр, Сумайн, Цайдам, Цагаан, Их халуун шаварт, Шорвог, Баян бүрд гэх мэт нууруудтай. Далайн түвшнээс дээш 560 метрт орших Монголын хамгийн нам доор газар Хөх нуур хэмээх тэгш тал байдаг.

Байгалийн бүс бүслүүрийн хувьд ойт-хээр, хээрийн бүс зонхилсон, 123.5 мян.км² нутагтай. Баруун, баруун хойт зүгийн агаарын урсгалаар ирэх чийгийн ихэнх нь Хэнтийн нуруунд саатдагаас Дорнод тал нутаг бол чийглэгдүү-сэрүүн, хуурайдуу-сэрүүвтэр, хуурайдуу дулаавтар уур амьсгалтай.




Зураг 8. Агаарын жилийн дундаж температур, жилийн нийлбэр хур тунадас

(Эх сурвалж: www.eic.mn)

Дорнод аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд олон жилийн дундаж агаарын температур нутгийн баруун хойд болон зүүн хэсгээрэй $-2.0\text{...}0.0\text{C}$, төвийн хэсгээрэй $+2.0\text{...}+4.0\text{C}$ байх бөгөөд бусад талбайгаар $0.0\text{...}+2.0\text{C}$ байдаг. Харин жилийн нийлбэр хур тунадас нутгийн баруун хойд болон зүүн хэсгээрэй $350\text{...}400\text{mm}$ төвийн хэсгээрэй $200\text{...}250\text{mm}$ байх бөгөөд бусад талбайгаар $300\text{...}350\text{mm}$ унадаг байна.

Дорнод аймгийн уур амьсгалын ерөнхий хандлагыг “Статистикийн мэдээллийн нэгдсэн сан”-гийн 2005-2021 оны буюу 16 жилийн мэдээг ашиглан боловсруулав.



Зураг 9. Агаарын температур болон хур тунадасны олон жилийн хандлага

2005-2021 оны олон жилийн явцаас харахад агаарын дундаж температур ойролцоогоор 1.1°C-аар дулаарсан бөгөөд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор сүүлийн жилүүдийн (2012 оноос) ерөнхий хандлага нэмэгдсэн нь Зураг 9-т харагдаж байна. Энэ хугацаанд хамгийн хүйтэн жил 2012 онд +0.2°C, хамгийн дулаан жил 2007 онд +3.6°C хүрч байжээ. Харин хур тунадасны олон жилийн өөрчлөлтөөс үзвэл өссөн хандлагатай бөгөөд жилийн нийлбэр хур тунадасны хэмжээ 140.7...428.6 мм-ийн хооронд хэлбэлзсэн байна.

2.3. Хэрлэн сумын уур амьсгалын горим


Чойбалсан сумын уур амьсгалын олон жилийн дундаж үзүүлэлтийг Монгол улсын “Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн” Дэлхийн цаг уурын байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу Хэрлэн цаг уурын харуулын (ДТД-747 м) 1991-2020 оны агаарын температур, хур тунадасны стандарт нормыг цаг хугацааны сарын алхамтай тооцоолсон мэдээг ашиглав (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Чойбалсан сумын уур амьсгалын олон жилийн дундаж үзүүлэлт

Үзүүлэлт	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
Сарын дундаж агаарын температурын үзүүлэлтүүд													
Дундаж	-17.3	-15.7	-4.3	5.5	13.7	20.3	22.6	18.6	12.9	2	-9.1	-18.7	2.5
Үнэмлэх их температур	-1.8	5.5	15.8	29.5	34.5	36	36.2	34.5	32	24.5	13.8	3.5	36.2
Үнэмлэх бага температур	-29.2	-32	-22.8	-11.6	-3.3	4.1	8.5	6.5	-1.4	-13.6	-24.7	-31.3	-32
Сарын нийлбэр хур тунадасны үзүүлэлтүүд													
Нийлбэр	0.5	1.5	0.4	0.2	12.4	46.9	32.4	53.2	13.4	11.8	1.6	1.4	175.5
Хамгийн их	0.7	1.6	0.5	0.3	8.6	35.4	13.4	30.2	8.4	6.1	1.4	2.2	35.4

Энэхүү мэдээлэл нь цаг уурын байгууллагаас гарч байгаа мэдээ мэдээллийн ерөнхий суурь нөхцөл болохоос гадна газар тариалан, харилцаа холбоо, барилга байгууламж, авто зам, ачаа тээвэр, эрчим хүч, хот төлөвлөлт зэрэг олон салбаруудын техникийн баримт бичгийн стандарт норм, дүрэм болж ашиглагдах зориулалттай.


Бид энэхүү судалгаандаа Чойбалсан сумын уур амьсгалыг тодорхойлохдоо “Цаг уур, орчны шинжилгээний газар, Байгаль орчин, ус цаг уурын мэдээллийн төв архив”-аас Хэрлэн харуулын сүүлийн 10 жилийн (2012-2021 он) агаарын температур, хур тунадас болон салхины мэдээ, материалыг авч ашиглав.



Зураг 10. Чойбалсан сумын агаарын температур

Чойбалсан сумын нутагт 2012-2021 оны хооронд дунджаар температур $-0.2...+4.7^{\circ}\text{C}$ -ын хооронд хэлбэлзсэн бөгөөд өвлийн улиралд $-18.5...-15.0^{\circ}\text{C}$, хаврын улиралд $-3.9...+12.7^{\circ}\text{C}$, зуны улиралд $+18.5...+22.4^{\circ}\text{C}$ харин намрын улиралд $-8.6...+12.9^{\circ}\text{C}$ хүрсэн байна. Тухайн бүс нутагт жилд орох хур тунадасны нийлбэр $167.2...212.0$ мм-ийн хооронд хэлбэлзэх бөгөөд өвлийн улиралд $0.5...1.7$ мм, хаврын улиралд $2.2...18.0$ мм, зуны улиралд $39.2...73.0$ мм, намрын улиралд $1.7...13.7$ мм-ийн хооронд хэлбэлздэг. Хамгийн их хур тунадас 8 сард дунджаар 73.0 мм, хамгийн бага хур тунадас 12 сард дунджаар 0.5 мм орчим ордог байна.


Гадаргын онцлог, агаарын массын улирлын шилжилт циклон ба эсрэг циклоны солигдох байдал зэргээс үүдэн Монгол оронд салхи ихтэй байдаг. Салхины горимын үндсэн үзүүлэлт болох салхины чиглэл ба хурд нутаг бүрд харилцан адилгүй байдаг.



Зураг 11. Чойбалсан сумын салхины хурд

Судалгаанд хамрагдаж буй нутагт салхины хурд жилд дунджаар 2.9 м/с байсан бөгөөд хавар, намрын улиралд өсөж өвөл, зуны улиралд буурсан байна. Салхины хурдны хамгийн их утга нь 5 сард дунджаар 4.0 м/с, хамгийн бага утга нь 7 сард 1.9 м/с ажиглагдсан. Салхины зүг чиглэлийн давтагдал нь тухайн орон нутгийн физик газарзүйн тогтолцооны

нөлөөлөлтэй. Салхины зонхилох зүг чиглэлийн давтагдлыг хувиар илэрхийлэн 4 улирлаар (Өвөл, хавар, зун, намар) 12-р зурагт үзүүлэв.



Зураг 12. Чойбалсан сумын салхины зүг, чиглэлийн давтагдал

Чойбалсан сумын салхины зүгийн давтагдал нь тухайн орон нутгийн физик газарзүйн тогтолцооны нөлөөлөлтэй жилд дунджаар баруун хойд зүгийн салхи 21-28%, хойд зүгийн салхи 22-25% түлхүү давтагддаг байна.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Тус төслийн үйл ажиллагааны улмаас хүрээлэн буй орчинд учрах болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, судалгаа явуулсан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн тодорхойлов. Төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөлөлд өртөгдөх байгалийн үндсэн тусгагдахуун нь агаар, ус, хөрс, ургамлан нөмрөг юм.

3.1. Нөлөөллийн хэлбэр үргэлжлэх хугацаа

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төслийн талбай болон орчны байдалтай танилцаж, холбогдох судалгааг хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо магадлан жагсаах аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэх) байдлыг үзүүлдэг.

Хүснэгт 7. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөөр зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд эрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсцын өөрчлөлт			х							
Гадаргын урсцын өөрчлөлт			х							
Ургамлын бүтцийн өөрчлөлт	х				х					х
Хөрсний элэгдэл, эвдрэл	х				х					х
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт			х							
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			х							
2. Байгалийн нөөц ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг			х							
Бэлчээрийн байдал			х							
Эрдэс түүхий эдийн нөөц			х							
Эрчим хүчний нөөц			х							
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Газрын доорх усны чанар, хэмжээ			х							
Гадаргын усны чанар хэмжээ			х							
Агаарын бохирдол			х							
Хөрсний бохирдол			х							

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөөр зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд эрэг	Бага зэрэг
Төслийн үйл ажиллагаанаас ялгарах бохирдуулагч бодис хүний эрүүл мэндэд нөлөөлөх			x							
Дуу чимээ, шуугианы нөлөө			x							
4. Байгалийн өнгө төрх, түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх			x							
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх			x							
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх			x							
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх			x							
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх			x							
5. Нийгэмд үзүүлэх нөлөө										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх		x			x				+	
Үйлчилгээний салбарын ү/а-нд нөлөөлөх		x			x					+
Хүн амын орлого өөрчлөгдөж, нэмэгдэх		x			x				+	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх			x							
6. Эдийн засагт үзүүлэх нөлөө										
Татварын орлого өөрчлөгдөх	x				x		x			+
Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x		x			+
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x		x			+
Ажлын байр нэмэгдэх	x				x		x			+
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x				x		x			+
7. Бусад нөлөөлөл										
Бохир ус хөрсөнд нэвчиж, хөрс ба грунтын усыг бохирдуулах			x							
Дүн	7	3	20	0	11	0	5	0	2	10

Төслийн болзошгүй сөрөг болон эерэг нөлөөллийн хэлбэр, хугацаа, эрчмийн үндэслэлийг дараах байдлаар гаргасан болно. Үүнд:

Шууд нөлөөлөл:

- Төслийн барилга байгууламжийн нөлөөгөөр биет хэмжээгээр хөрс, ургамлан бүрхэвч үүсмэл хэлбэршлээр солигдож, шууд, урт хугацаанд сөрөг нөлөөлнө;
- Дэд бүтцийн хөгжилд эергээр, урт хугацаагаар нөлөөлнө;

- Орон нутгийн орлого, ажлын байр нэмэгдэх зэрэгт төслийн үйл ажиллагаа явагдах хугацаанд болон цаашид эергээр нөлөөлнө;

Шууд бус нөлөөлөл:

- Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд урт хугацаанд эерэг нөлөөлнө;

Хүчтэй нөлөөлөл:

- Болзошгүй нөлөөллийн үнэлгээ хийх явцад төслийн зүгээс хүчтэй нөлөөлөх нөлөө байхгүй байна.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Зорилго: Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

Гол зорилтууд:

- Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;
- Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх;

Хүснэгт 8. 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нэгтгэл

№	Арга хэмжээ	Нийт төгрөг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	5,080,000
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	2,805,000
3	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	УАЗ
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,200,000
5	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	4,200,000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	246,800
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	УАЗ
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	УАЗ
Нийт дүн		14,531,800

5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (Төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
1	Агаарын бохирдол үүсэх	Ил задгай хог хаягдал шатаахгүй байх	Төслийн талбайд	тогтмол	Үйл ажиллагааны зардал		2024 он	2024 он	Агаарын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль MNS 4585:2016
2	Авто тээврийн хэрэгслээс хорт хий ялгарах, дуу чимээ тархах	Үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглаж буй машин техникийг үзлэг, оношилгоонд тогтмол оруулж, засвар үйлчилгээг шаардлагын дагуу хийж гүйцэтгэж байх	Үйлдвэрийн машин	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардал				
3	Машин техникийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт	Химийн бодисын тээвэрлэх, буулгалт хийх талбайг тэмдэгжүүлэх	Агуулахын эзэмшлийн талбайд	тогтмол	-	-	Үйл ажиллагааны зардлаар	2024 он	
4		Талбайн орчимд усалгаа, цэвэрлэгээ хийх, автомашины явалтаар үүссэн тоосонцрыг зайлуулах	Агуулахын орчимд	тогтмол	-	-	Үйл ажиллагааны зардлаар	2024 он	
Дүн							-		
Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
5	Усан орчин бохирдох, Усны нөөц хомсдох	Борооны ус хуримтлуулан дахин ашиглах зөвлөмж	Ус хэмнэх	ширхэг	-	1 удаа	100,000	2024 он	“Усны тухай хууль” Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль MNS 6561:2015 MNS 4943:2015 MNS 6734:2018 “Усны тухай хууль”
6		Ус хэмнэх технологи хэрэгжүүлэх /ариун цэврийн өрөөнд ус хэмнэдэг сантехникийн төхөөрөмжүүдийг суурилуулах/	Иж бүрэн	ширхэг	Үйлд ажиллагааны зардал		2024 он		
7		Ус бохирдуулсны төлбөр төлөх	Хаягдал бохир усны цооног	удаа	120.000	Жилд 1 удаа	120,000	2024 он	
8									

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (Төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
9		Ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоож мөрдөж ажиллах	Төслийн талбай	удаа	Үйлд ажиллагааны зардал			2024 он	БОНХАЖ-ын сайд, БХБ-ын сайдын хамтарсан тушаал-А-230/127 тоот журам “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”
Дүн							220,000		
Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
10	Хөрсний бохирдол	Барилга байгууламжийн гадна талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчныг цэвэр байлгах	Төслийн талбай	удаа/ жилд	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд тусгагдсан			2024 он	MNS 5850:2019, “Хөрсний чанар, хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 3297:2019, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүй үзүүлэлт, бохирдлыг үнэлэх”
11		Авто зогсоолыг хатуу хучилттай болгох	Төслийн талбай	м ²	8,100	600	4,860,000	2024 он	
12		Хөрсөн орчны мониторинг судалгааг хийх	Төслийн талбайн хөрс	удаа	-	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан		2024 он	
13		Төслийн хог хаягдлыг орон нутгаас зөвшөөрөгдсөн цэгт хаяж зайлуулах	Төслийн талбайд	Тогтмол	Үйл ажиллагааны зардал			2024 он	
14		Авто машины зогсоол дээр асгарсан тос, тосолгооны материалыг тухай бүрд нь цэвэрлэж авах	Төслийн талбайд	удаа	Үйл ажиллагааны зардал			2024 он	
Дүн							4,860,000		
Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
15	Ургамал	Сул чөлөөт талбайг тарималжуулж нөхөн сэргээх зөвлөмж	Төслийн талбай	удаа	Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ тусгагдсан			2024 он	Нөхөн сэргээлтийн аргачлал Хөрс хамгаалах,

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (Төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг	
16		Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж мод тарих	Төслийн талбай	ш	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд тусгагдсан			2024 он	цөлжилтөөс сэргийлэх тухай	
Дүн										
Нийт дүн									5,080,000	

6. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 10. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ногоон байгууламж бий болгох	Хайлаас	Мод бут тариална., шар хуасан хашаанд	ш	200	2,000,000	2024 он	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
2	Хар шороо	Хар шороо, элс, бордоо зэргийг бэлтгэх	Ногоон байгууламжийн арчилгаа	Машин	2	680,000	2024 он	
3	Элс			Шуудай /40кг/	2	50,000	2024 он	
4	Гумины бордоо			Уут	10	75,000	2024 он	
Нийт дүн						2,805,000		

7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвийг хамгаалах зорилгоор төсөл хэрэгжүүлэгч нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Соёлын өвийг хамгаалах, хадгалах Монгол улсын хууль эрхзүйн орчныг дагаж мөрдөх;
- Төслийн үйл явцад ямар нэг түүх соёлын дурсгалын шинжтэй зүйл илрүүлсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-ын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авах үүрэг хүлээн ажиллана;

Хүснэгт 11. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал,төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Төслийн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирж болзошгүй.	Хэрэв төслийн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирэхэд төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой.	Төсөл хэрэгжүүлэх нийт талбайн хэмжээнд	-	Тухайн үед нь шийдэх	Тухайн үед нь шийдэх	Үйл ажиллагааны турш	Соёлын өвийг хамгаалах тухай хууль /2014 оны 05 сарын 15-ны өдрийн шинэчилсэн найруулга/, Бусад холбогдох салбарын яамнаас гаргасан дүрэм журмууд

8. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 12. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Байгалийн давтагдашгүй хүчин зүйл болох	Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Нийт ажилчид	Жил 1 удаа	71 хүн		Гэрээний үнийн дүнгээр	2024 он	MNS 5002:2000, “ХАБЭА. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага” MNS ISO 13688:2000, “ХАБЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага” MNS 5390:2004, “ХАБЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага”
2	Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл	Ажлын идэвхтэй талбайг тойруулан хангалттай/зохистой гэрэлтүүлж, гэрэл цацруулагч саад тавих	Төслийн талбайн эрүүл ахуйн хамгаалалтын бүс	Иж бүрэн	1		Үйл ажиллагааны хүрээнд	2024 он	
3		Гал гарах зэрэг онцгой нөхцөлд хариу ажиллах бэлэн байдал (журам мөрдөх, ажилчдыг сургах, тоног төхөөрөмж, хэрэгсэл, хангамж),	Төслийн талбай	тогтмол	-	1,700,000		2024 он	
4		Төслийн тухай мэдээллийн самбар байршуулах.	Төслийн талбай	Иж бүрэн	1	500,000		2024 он	
5	Ажилчдын эрүүл мэнд,	Ажилчид ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл, аюулгүй байдлын дүрмийг хатуу мөрдөх талаар танилцуулах	Ажилчдад	Тогтмол	1		Үйл ажиллагааны хүрээнд	2024 он	Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
6		Ажиллагсдыг зориулалтын иж бүрэн хувцас хэрэгслээр хангах	Ажилчдад	Иж бүрэн	71 хүн		Үйл ажиллагааны хүрээнд	2024 он	
7		Ажилчдыг эрүүл мэндийн хугацаат үзлэг, шинжилгээнд хамруулах	Ажилчдад	Жил 1 удаа	71 хүн		Гэрээт ажлын дүнгээр	2024 он	
8	Галын аюулгүй байдлыг хангаагүйгээс гал түймрийн осол аварг өртөх	Болзошгүй аюул ослын үед ашиглах бүрэн ажиллагаатай галын хор, багаж хэрэгслүүдийг бүх объектуудад байрлуулах, галын аюулын үед ашиглах ослын гарцын зураглал хийж үйлдвэрийн доторх хананд байршуулах /Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл болох лоом, хүрз, сүх, хөрөө, хувин, хоолой, багор дэгээ, жоотуу, тармуур, хөөс, хорны	Төслийн талбай	Тогтмол			Үйл ажиллагааны хүрээнд	2024 он	Галын аюулгүй байдлын тухай хууль, 2015 он Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017 он

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
9		суурь, тэмдэг тэмдэглээ, сарай, элсний хайрцаг, шланг зэргийг бэлэн байлгах./							Хөдөлмөр хамгаалал стандартын систем. Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага MNS 4244:1994
		Ажилчдыг галын хор болон бусад хэрэгслийг ашиглаж сургах, дадлага эзэмшүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авах	Төслийн талбай	удаа	Жилд 1	Үйл ажиллагааны хүрээнд		2024 он	Гал гарах үед анхааруулгын самбар, объектоос гарах схем зураглал, галын хорын нэгж талбайд ноогдох стандарт MNS 5566: 2020
Нийт дүн						2,200,000			

9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын цэгийг тохижуулах	Хог хаягдлын цэг	Иж бүрэн	1 удаа	4,000,000	4,000,000	2024 он	БОАЖ-ын сайдын А/433 тогтоол Хог хаягдлын тухай хууль
2	Эзэмшил газрын ил задгай хаягдсан хогийг ангилан ялгаж цэвэрлэж байх	Төвийн ойр орчмын 100 метрт	Тогтмол	Үйл ажиллагааны зардал		2024 он		
3	Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх	Дахин ашиглагдах хог хаягдал	Тогтмол	Үйл ажиллагааны зардал		2024 он		
4	Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлэх	Хог хаягдлын цэгт	Тогтмол	Улиралд 1 удаа	50,000	200,000	2024 он	
5	Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх сургалт хийх	Үйлдвэрийн ажилчдад	удаа	Үйл ажиллагааны зардал		2024 он	Засгийн газрын 116 тогтоол	
6	Үүсэх хог хаягдлын төрөл, кодыг ЗГ-ын 116 тогтоолд заасан хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу тогтоосон байх	Төслөөс үүсэх хог хаягдал	удаа	Үйл ажиллагааны зардал		2024 он		
7	Химийн бодисын сав баглаа, боодол устгахдаа эрх бүхий мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан устгуулах	Төслөөс үүсэх аюултай хог хаягдал	Тогтмол	Гэрээний дүнгээр		2024 он	Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх журам	
Нийт дүн						4,200,000		

10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хуваарь

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал,төг	Хууль, бодлого, стандарт
Агаарын чанар						
CO ₂ , NO ₂ , SO ₂ Тоос нийт (PM10, PM2.5) Дуу шуугиан хэмжээ	- Үйлдвэрийн байр дотор -1 цэг 114°34'8.416"E 48°4'44.654"N - Төслийн талбайн хашаан дотор-1 цэг 114°34'5.257"E 48°4'42.619"N	Улиралд 1 удаа	2 цэгт	106,000	106,000	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн шаардлага
Хөрс						
Нянгийн шинжилгээ/ Нянгийн ерөнхий тоо, гэдэсний бүлгийн нянгийн тоо, гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян, E.Coli халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нянгийн тоо/	- Хогийн цэг – 1 цэг 114°34'7.451"E 48°4'40.91"N	Жилд 1 удаа	1 цэгт	27,500	27,500	- MNS 3297:2019, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх”
Хөрсний хүнд металлууд	- Төслийн талбайн ил гарсан хөрснөөс-1 цэг 114°34'5.173"E 48°4'43.607"N	Жилд 1 удаа	1 цэгт	30,800	30,800	- MNS 5850:2019, “Хөрсний чанар, хөрсөнд агуулагдах бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ”
Усны чанар						
Усны ерөнхий хими, Бактериологи	- Унд, ахуйн ус 114°34'10.662"E 48°4'44.613"N	Жилд 1 удаа	1 цэгт	82,500	82,500	- MNS 0900:2018 “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ”
Нийт дүн					246,800	



Зураг 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн мониторингийн цэгийн зураг

11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 15. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хугацаа хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он				
			Сар	Сар	Сар		
1	2	3	4	5	6	7	
1	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх (5 жилд 1 удаа).	Гэрээт ажлын дүнгээр	8-р сар			Үйлдвэрийн дарга	Газрын тухай хууль
2	Төсөл хэрэгжих орон нутгийн удирдлагатай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах.	Тохиролцох			9-10 сар	Үйлдвэрийн дарга	Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3
3	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Дотоод төлөвлөлтөөр	4-р сар			Үйлдвэрийн дарга	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
4	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, тухайн жилийн БОМТ-г батлуулж байх	Үйл ажиллагааны зардал			11-12 сар	Байгаль орчны мэргэжилтэн	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.12-р заалт, БОАЖ-ын сайдын 2019 оны А/618 тоот тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
10							
Нийт зардал		-					

12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Хүснэгт 16. Тухайн жилийн БОМТ-ийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх арга хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
БОАЖЯ	БОМТ-н жилийн төлөвлөгөө	БОННУ-р тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах, зөвлөмж, батлагдсан БОМТ-нд үндэслэн тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах	Жил бүрийн 12-р сард	Төлөвлөгөө батлуулах	БОАЖЯ
Дорнод аймгийн БОАЖГ-т	БОМТ-н жилийн тайлан	Төлөвлөгөөний хэрэгжилт, ОХШХ-н хэрэгжилт	Жил бүр 11-р сарын 1-ний дотор	Тайлан хянуулах	Дорнод аймгийн БОАЖГ
Нийт дүн			-		